



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОР С. ТӨМӨР-ОЧИР ТАНАА

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Бага тойруу, Утас: 32-51-09, 32-47-09, Факс: (976-11)32-41-21
<http://www.must.edu.mn>

2012. 05. 14 № 1/267

танай _____ -ны № _____ -т

Г Олон улсын Эрдэм шинжилгээний хурлын тухай

Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль “Дэлхийн түвшинд хүрсэн их сургууль байгуулах санаачилга-2012” (Building a World Class University: Challenges and Initiatives-2012) сэдэвт Олон улсын Эрдэм шинжилгээний хурлыг 2012 оны 6 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд ШУТИС дээр зохион байгуулах гэж байна.

ШУТИС нь орчин үеийн дээд боловсролын өөрчлөлт, шинэчлэл ба их сургуулийн менежментийн шилдэг туршлага, загварын талаар олон улсын туршлагаас суралцан “Дэлхийн түвшинд хүрсэн их сургууль” –д хүрэх арга замыг тодорхойлон хэлэлцэх зорилгоор энэхүү Олон улсын Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байгаа юм.

Тус хурлаар дараах үндсэн асуудлуудыг хэлэлцэх юм. Үүнд:

- Дэлхийн түвшинд хүрсэн их сургууль байгуулах бодлого ба санаачилгүүд – Мэдлэгт суурилсан эдийн засгийн харилцааг бий болгоход их сургуулийн гүйцэтгэх үүрэг, дэлхийн түвшинд хүрсэн их сургуулийн шалгуур үзүүлэлтүүд, орчин үеийн их сургуулийн эдийн засаг, менежмент, их сургуулийн хотхоны хөгжлийн бодлого
- Инженерийн дээд боловсролын өөрчлөлт, шинэчлэл – Инженерийн боловсролын шинэчлэлийн дэлхий нийтийн CDIO санаачлага, их сургуулийн ахисан түвшний сургалтын агуулга, хэлбэр, арга зүйн өөрчлалт шинэчлэл, сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх шинэ технологи, инноваци
- Их сургуулийн инноваци ба энтрепренер үйл ажиллагааг хөгжүүлэх – Их сургуулийн инновацийн үйл ажиллагаа, их сургуулиас үйлдвэрлэл, бизнест чиглэсэн технологи дамжуулалт, энтрепренер их сургуулийг хөгжүүлсэн шилдэг загвар, туршлага, төр, их сургууль ба бизнесийн салбарын харилцан түншлэл

Одоогийн байдлаар тус хуралд ОХУ, АНУ, БНХАУ, БНСУ, Тайван, Польш, Япон, Франц зэрэг орнуудын их сургууль, олон улсын байгууллагууд, манай улсын их, дээд сургуулиудын төлөөлөгчид дээрх чиглэлүүдээр олон сонирхолтой илтгэл хэлэлцүүлэхээр урьдчилан мэдэгдээд байна.

Иймд таныг болон танай сургуулийн төлөөлөгчдийг тус хуралд илтгэл тавьж оролцохыг урьж байна.


Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.must.edu.mn/bwcuci2012/> веб хуудаснаас авна уу.

Хуралд оролцох талаар мэдээлэлээ 329081, 329746 утсаар болон nasaa@must.edu.mn, ochirbat@must.edu.mn хаягаар харилцаж мэдэгдэхийг хүсье.

Та бүхнийг тус хуралд өргөнөөр идэвхтэй оролцож, бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Хүндэтгэсэн,

РЕКТОР



Б.ДАМДИНСҮРЭН

3670267